



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Сургалтанд хамруулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 11.7, 13.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан эдийн засагч М.Жавхланчимэг, Ус хангамж ариутгах татуургын инженер Ч.Батхишиг, Архивын эрхлэгч А.Анхзаяа нарыг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 6-ны өдрийг дуустал, Цахилгааны инженер О.Нямбаяр, Төсвийн мэргэжилтэн Х.Энхбаясгалан нарыг 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 5-ны өдрийн дуустал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамны дэмжлэгтэйгээр Азийн орнуудын дунд зохион байгуулж буй “Аж үйлдвэрлэлийн паркийн бүтээн байгуулалт, төлөвлөлт ба менежмент” сэдэвт тэтгэлэгт сургалтанд тус тус суралцуулсугай.

2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан эдийн засагч М.Жавхланчимэг, Ус хангамж ариутгах татуургын инженер Ч.Батхишиг, Архивын эрхлэгч А.Анхзаяа Цахилгааны инженер О.Нямбаяр, Төсвийн мэргэжилтэн Х.Энхбаясгалан нарын сургалтанд хамрагдсан хугацааны цалинг батлагдсан төсвийн үндсэн цалингийн зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /Б.Пүрэвсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Гадаад сургалтын тайланг ирснээс хойш 7 хоногийн дотор Даргын зөвлөлд танилцуулахыг тус тушаалын 2 дугаарт заасан ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГА



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

3150800079